



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДУУРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар A/15

Улаанбаатар хот

Г Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлэх тухай

Гамшигаас Хамгаалах Тухай Хуулийн 11.2, 11.3.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоол, Хан-Уул Дүүргийн Засаг Даргын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн A/88 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2020 оны 02-р сарын 13-ны өдрөөс 2020 оны 03-р сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд эмнэлгийн үйл ажиллагааг гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

Хоёр. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярын нэгдсэн золголтыг хийхгүй байх нь зүйтэй гэж үзсүгэй.

Гурав. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ГХАлбаны штабын дарга бөгөөд Эмнэл зүй, тусламж үйлчилгээ эрхэлсэн орлогч дарга /Д. Мажигсүрэн/-д даалгасугай.

3.1. ГХАлбаны үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж, ажилтан албан хаагчдын амралт чөлөөг хязгаарлах, шаардлагатай тохиолдолд ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах.

3.2. Шинэ коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдлыг хангаж Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөнд тодотгол хийх.

3.3. ГХАлбаны даргын шийдвэрт заасан үйл ажиллагааны чиглэл, өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх.

3.4. Зарлан мэдээллийн бэлэн байдлыг хангаж ГХАлбаны болон штабын бие бүрэлдэхүүний утсыг цаг ямагт нээлттэй байлгах.

3.5. Эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангах, үүсч болзошгүй эрсдэл, аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар штабын гишүүд болон албадын менежер нарт Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөөний дагуу зааварчилгаа өгч баталгаажуулсан байх.

Дөрөв. Нийслэлийн Засаг Даргын А/168 тоот захирамж, Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан / С.Шаравсэнгэ/, ОУХХ, хурц халдварт өвчний асуудал хариуцсан ажилтан / Г.Нармандах/ нарт үүрэг болгосугай.

Тав. Шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн халад, амны хаалт, эм урвалж, халдвартгүйтгэлийн бодисын нөөц, хамгаалах хувцас, хүчилтөрөгчийн хангамжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Ар тал хангарт хариуцсан ажилтан /Г.Одончимэг/-д даалгасугай.

Зургаа. Өндөржүүлсэн бэлэн байдлын үеэр ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилга бат, сонор сээрэмжээ дээшлүүлж ажиллахыг эмч эмнэлгийн ажилтнуудад үүрэг болгосугай.

Долоо. Шинэ коронавирусийн халдварын сэжигтэй өвчтөн ирэх үед үзүүлэх тусламж үйлчилгээ, авах арга хэмжээний зураглал алгоритмийг гаргаж тасаг нэгжүүдэд байршуулж, сургалт зохион байгуулахыг ГХАШтабын дарга /Д.Мажигсүрэн/, Төлөвлөлт бэлэн байдал, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтан /Ц.Жавзан-Орлом/ нарт даалгасугай

Найм. Болзошүй эрсдлийн үед ариутгал халдвартгүйтгэл хийх журмыг өөрийн эмнэлгийн нөхцөлд тохируулан гаргаж эмнэлгийн цэвэрлэгээ, ариутгал, халдвартгүйтгэлийг сайжруулж ажиллахыг Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан / С.Шаравсэнгэ/, ОУХХ, хурц халдварт өвчний асуудал хариуцсан ажилтан /Г.Нармандах/ нарт үүрэг болгосугай

Ес. Томуугийн цахим хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж мэдээ мэдээллийг сайжруулж ажиллахыг Статистик бүртгэл мэдээ мэдээ-лэл хариуцсан ажилтан /Т.Арвинтөгөл/, ОУХХ, хурц халдварт өвчний асуудал хариуцсан ажилтан / Г.Нармандах/ нарт үүрэг болгосугай

Арав. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж, хэрэгжилтийг долоо хоногийн Баасан гараг бүр ГХАлбаны штабын хуралд хуралд танилцуулж байхыг Штабын нарийн бичгийн дарга / Б.Ану /- даалгасугай .

ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАНЫ ДАРГА

Д.БААСТ



D: Erunkhii emchiin tushaal